



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/213

Улаанбаатар хот

Төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16.51, ШУТИС-ийн дүрмийн 4.14.4, 9.4.8, 10.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн хэмжээнд явагдаж буй төлбөрт үйлчилгээний болон туршилт үйлдвэрлэлийн ажлыг нэмэгдүүлэх зорилгоор нийтлэг байгаа төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, бүрэлдэхүүн сургууль, төв, лабораториудаас үзүүлж буй төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвүүдэд явагдаж байгаа түр сургалтын төлбөрийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвүүдэд туршин үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний үнийг тухайн сургуулийн захирлын тушаалаар баталж, мөрдөж ажиллахыг зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хэмжээний дагуу бэлнээр болон бэлэн бусаар төлбөрийг хийлгэж, тасалбар, тооцооны хуудсыг үндэслэн төлбөрт үйлчилгээг үзүүлж байхыг бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвийн холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.


4. Үйлчилгээ явуулахад шаардагдах тасалбар, тооцооны хуудсыг батлагдсан загварын дагуу хэвлэн бэлтгэх, төлбөрийн тооцоог хийж, төсөв санхүүгийн журмын дагуу тайлагнаж байхыг ахлах нягтлан бодогч нарт даалгасугай.

5. Төлбөрт үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг СХОЭ дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ), бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, нэгжийн дарга, эрхлэгч, СНББАлбаны дарга (Д.Барсболд) нарт даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ректорын 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн "Төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг батлах тухай" А/12 тоот тушаал, 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн "Төлбөрт үйлчилгээний журам, төлбөрийн хэмжээг батлах тухай" А/227 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэхүү тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

307041191

ШУТИС-ийн Захирлын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 148 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ШУТИС-ийн хэмжээнд нийтлэг байгаа төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ

Нэг. Сургалттай холбоотой нийтлэг үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ

№	Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ/төгрөгөөр/	Тайлбар
1	Оюутны үнэмлэх авах	ширхэг	5000	Анх авахад үнэгүй, дахин авахад энэхүү төлбөрийг төлнө.
2	Хичээл сонголт 1-ээс хоцорсон тохиолдолд	1-21 кр	200000	Хичээл сонголт-1 хийгээгүй оюутанд тухайн улиралд захиалсан нийт кредитээс үл хамааран мөнгөн торгууль ноогдуулна.
3	Сургалтын албанаас болон автомат машинаас дүнгийн хуудас, суралцагчийн тодорхойлолт авах	удаа	1000	Улиралд 2 удаа үнэгүй, түүнээс дээш бол энэхүү төлбөрийг тухай бүр төлнө.
4	Төгсөгчийн тодорхойлолт авах	удаа	5000	
5	Төгсөлтийн ёслолын хувцас түрээслэх	ширхэг	5000	
6	Багшийн дэвтэр	ширхэг	10000	Анх авахад үнэгүй, дахин авахад энэхүү төлбөрийг төлнө.
7	Оюутны дэвтэр	ширхэг	15000	
8	Оюутны гарын авлага	ширхэг	15000	

Хоёр. Эмнэлэгийн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ

Нөхөн сэргээх физик эмчилгээ

№	Эмчилгээний нэр	Эмчилгээ /төгрөг/		Курс эмчилгээ /төгрөг/	
<i>Бариа засал</i>					
1	Толгойн бариа	1 удаа	5000	Зудаа	15000
2	Хэсгийн бариа	1 удаа	5000	3 удаа	15000
3	Хүзүү сэргээний бариа	1 удаа	5000	5 удаа	25000
4	Бүх биеийн бариа	1 удаа	30000	5 удаа	130000
5	Нүүрний цэгэн бариа	1 удаа	5000	7 удаа	35000
<i>Засал эмчилгээ</i>					
6	Банк	1 удаа	1000	3 удаа	2500